



“МАНДАЛ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК”
ХХК-Д

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2021. 08. 18 № 1 / 2789
танай _____ -ны № _____ -т

Хоёрдогч зах зээлийн арилжааг
эхлүүлэх зөвшөөрөл олгох тухай

“Мандал ирээдүйн өсөлт” хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл хүсэх тухай 2021 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 21/070 тоот албан бичиг болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсан талаарх 2021 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 01/308 тоот албан бичигтэй тус тус танилцлаа.

Хорооны 2014 оны 175 дугаар тогтоолоор баталсан “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 8.13-д “Хороо нэгж эрхийг анхдагч зах зээлд амжилттай болсонд тооцсон нөхцөлд тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлж болно” гэж заасан бөгөөд “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Мандал ирээдүйн өсөлт” хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг 2021 оны 8 дугаар сарын 19-ний өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хувийг: “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, “Голомт банк” ХХК-ийн Кастодиан банкны хэлтэст.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

151800007012